САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

2020.07.29

*ТА **ИНТЕРНЕТ БАНК** БОЛОН **319708, 319709** УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.*

Валют	Ханш	24H Chg
EUR/USD	1.1722	0.05%
USD/CNY	7.0031	-0.05%
USD/RUB	72.59	0.00%
USD/JPY	105.16	0.07%
USD/KRW	1196.6	-0.04%
USD/CHF	0.9182	1.37%
AUD/USD	0.7165	-0.01%
GBP/USD	1.2926	0.00%
Индекс	**Нэгж**	**24H Chg**
Dow Jones	26379.3	-0.77%
S&P 500	3218.4	-0.65%
NASDAQ	10402.1	-1.27%
FTSE 100	6129.3	0.40%
Nikkei 225	22523.1	-0.59%
DAX	12835.3	-0.03%
Hang Seng	24772.8	0.69%
SHCOMP	3228.0	0.71%
Метал	**Ханш (USD)**	**24H Chg**
Алт	1959.98	0.08%
Мөнгө	24.4815	0.33%
Нүүрс (Чин хуанг дао/юань)	569	0.00%
Хүрэн нүүрс (БНХАУ)	33.3	-0.09%
Зэс (LME)	6477	0.88%
Төмрийн хүдэр	827	0.55%
Газрын тос (NYME)	41.13	0.22%
Бонд	**Хүү**	**24H Chg**
US 1M LIBOR	0.17%	-3.70%
US 3M LIBOR	0.27%	9.27%
US 6M LIBOR	0.32%	-0.59%
US 12M LIBOR	0.46%	-0.57%
US Treasury 10Y	0.58%	0.00%
UK Treasury 10Y	0.11%	0.00%
GE Treasury 10Y	-0.51%	-3.46%
JP Treasury 10Y	0.02%	-4.35%

Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24H Chg
Гэрэгэ	5.63%	5/1/2023	4.93%	0.06%
Мазаалай	10.8%	4/6/2021	4.01%	-0.03%
Хуралдай	8.75%	3/9/2024	5.57%	-0.03%
Чингис	5.13%	12/05/2022	4.76%	-0.03%
Самурай	5.75%	12/25/2023	1.26%	0.08%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	6.69%	0.10%
МИК 2022	9.75%	1/29/2022	17.63%	0.00%
ММС	9.25%	4/15/2024	18.68%	0.05%

Онцлох мэдээ

- Японы Засгийн газар 2021 оны 3-р сарын санхүүгийн жилд бодит ДНБ-ээ 1.4% тэлнэ гэсэн коронавирусын өмнөх таамаглалаа шинэчлэн 4.5 орчим хувиар агшина гэж тооцсоныг Nikkei бизнесийн өдөр тутмын мэдээ мэдээлжээ.
- Ардчилсан намтай 1 тэрбум ам.долларын тусламжийн хөтөлбөрийн тухай хэлэлцээрт тохиролцож чадаагүй тул Цагаан ордон болон АНУ-ын Конгресс дахь Бүгд Найрамдахчуудын төлөвлөгөө тодорхойгүй байдалд орлоо.

Валютын зах зээл

АНУ-ын хэрэглэгчийн итгэлийн индекс 7-р сард дахин буурсан үзүүлэлттэй гарснаар коронавирусын халдвар нь хэрхэн хүмүүсийн хэрэглээнд сөргөөр нөлөөлснийг илтгэж байна. Улмаар маргааш зарлагдах ХНБ-ны ээлжит хурлаар мөнгөний илүү зөөлөн бодлого баримталсан шийдвэрүүд гаргаж магадгүй байна. Энэ нь цаашид ам.долларын ханшийг улам унагах магадлалтай байгаа ба одоогоор ам.долларын DXY индекс 2018 оны 6-р сараас хойших хамгийн доод цэг 93.713 нэгжид хүрчээ.

Сүүлийн 22 сарын дээд цэгээ тогтоосон еврогийн ханш ам.долларын эсрэг 1.1723 нэгж рүү буцлаа. Мөн 4 сар хагасын чанга ханшаа тогтоосон Японы иенийн ханш ам.долларын эсрэг 105.04 рүү бага зэрэг суларсан байна. Английн фунтийн ханш мөн 4 сар хагасын дээд цэг 1.2952 нэгжээс бага зэрэг буурч 1.2935 дээр арилжаалагдаж байна. Харин Австрали долларын ханш дотоодын инфляцийн тоо мэдээнээс өмнөхөн 0.7158 дээр хэлбэлзэж байна.

Алтны зах зээл

Хөрөнгө оруулагчид өдрийн сүүлээр гарах АНУ-ын ХНБ-ны хурлын дүнг хүлээх зуур, COVID-19 халдварууд ихсэж байгаад санаа зовниж буй болон засгийн дэмжлэгээс үүдэх магадлалтай инфляци алтны ханшийг Лхагва гарагт тогтворжуулаад байна. Спот ханш нь Лондонгийн нэг цагийн үед үл ялиг өөрчлөлттэй унц нь 1,957.84 ам.доллартай тэнцүү байна. Мягмар гарагт бүх цаг үеийн хамгийн дээд цэг болох $1,980.57 хүрсний дараа хөрөнгө оруулагчид ашгаа авч, ам.доллар бага зэрэг өссөнөөр буцаж буулаа. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.5% дээшилж 1,954.50 ам.доллар хүрлээ. Дэлхийн хамгийн том алт барьцаалсан арилжааны сан SPDR Gold Trust GLD эзэмшиж буй алтны хэмжээ Мягмар гарагт 0.7% өсөж 1,243.12 тонн болсон талаар мэдээллээ.

Зэсийн зах зээл

Өнөөдрийн Азийн зах зээлийн нээлтийн арилжаагаар Лондонгийн зэс буурсан бөгөөд БНХАУ 4-р сараас хойш хамгийн их вирусын халдварын тохиолдлыг бүртгэж, АНУ-ын 5 муж нэг өдрийн рекорд дээд COVID-19-ийн нас баралтыг тогтоосноор сүүлийн 3 арилжааны анхны

Хувьцаа	Ханш	24H Chg
Turquoise Hill Resources	0.8595	-3.82%
Mongolian Mining Corp	0.47	-2.08%
Mongolian Energy Corp	0.60	-1.64%
Centerra Gold	16.2	-2.64%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2020 (VI)	2.8%
Бодлогын хүү	2020 (IV)	9.0%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020 (V)	8.9%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2020 (VI)	11.0%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2020 (VI)	4.3%
Зээлийн дундаж хүү (төг)	2020 (VI)	17.0%
Зээлийн дундаж хүү (валют)	2020 (VI)	10.4%

Ханшийн таамаглал

Валют	Q3 20	Q4 20	Q1 21	Q2 21	2021
EUR/USD	1.12	1.14	1.14	1.15	1.17
GBP/USD	1.25	1.26	1.28	1.29	1.32
USD/CNY	7.05	7.04	7.02	6.94	6.99
USD/JPY	107	107	107	107	107
USD/RUB	70	70	69.5	68.0	69.1
Түүхий эд					
Алт	1789	1806	1821	1824	1824
Зэс	6073	6072	6075	6086	6092
Нүүрс	46.0	48.0	49.0	49.0	47.0

Эдийн засгийн голлох тоо мэдээ *эх сурвалж: Блүүмбэрг*

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
US Consumer Confidence	92.6	94.5	98.1
Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	**Цаг**	**Таам.**	**Өмнөх**
GE Import Prices MM	14:00	0.5%	0.3%
GE Import Prices YY	14:00	-5.1%	-7.0%
FR Consumer Confidence	14:45	99	97
IT Producer Prices YY	16:00	-	-5.3%
Маргааш хүлээгдэж буй мэдээ	**Цаг**	**Таам.**	**Өмнөх**
US Fed Funds Tgt Rate	2:00	0.25%	0.25%
US Fed Int On Excess Reserves	2:00	-	0.10%
GE Unemployment Chg SA	15:55	43k	69k
GE Unemployment Rate SA	15:55	6.5%	6.4%
GE GDP Flash QQ SA	16:00	-9.0%	-2.2%
GE GDP Flash YY SA	16:00	-10.9%	-1.9%
US GDP Advance	20:30	-34.1%	-5.0%
US Initial Jobless Claims	20:30	1450k	1416k

бууралт руу чиглэлээ. Хөрөнгө оруулагчид 2 өдөр үргэлжилсэн ХНБ-ны уулзалтаар орон сууцжуулах бодлогын талаар дахин хэлэлцэж бодлогын хүүг доогуур түвшинд тогтоон барина гэсэн хүлээлттэй байна. Мягмар гарагт Лондонгийн Металлын Бирж дээр зэс 0.9% өсөлттэй хаагдсаны дараа 01:52 цагт 0.4% буурч $6,453.50 дээр арилжаалагдав. Харин Шанхайн Фьючерсийн Бирж дээр зэс 0.1% өсөж 51,750 юань ($7,392.33)-д арилжаалагджээ.

Газрын тосны зах зээл

АНУ болон бусад орнуудад коронавирусын халдварын рекорд өсөлт бүртгэгдсэн ч АНУ-ын нефтийн нөөц таамаглалын эсрэг унасан тоон мэдээ гарснаар зах зээлд дэмжлэг өгөн улмаар газрын тосны ханш өслөө. Брент өчигдөр 0.4% буурсны дараа 03:26 цагийн байдлаар 14 цент (0.3%) өсөж $43.36-т арилжаалагдсан. WTI мөн адил өмнөх арилжаагаар 1.4% уналт үзүүлсний дараа өнөөдөр 2 цент ахиж $41.06-т арилжаалагдлаа. Америкийн Нефтийн Хүрээлэнгийн тоон мэдээгээр өнгөрөгч долоо хоногт түүхийн нефтийн агуулах дахь нөөц 6.8 сая баррелаар буурч 531 сая баррел болжээ. Шинжээчид 357 мянган баррелаар өснө гэж таамаглаж байв.

Бондын зах зээл

Гадны хөрөнгө оруулалтын сангуудын Азийн хөгжиж буй зах зээлээс худалдан авсан бонд өндөр дүнтэй байлаа. Тодруулбал, Блүүмбергийн цуглуулсан мэдээллээр гадны сангууд 7-р сарын 27-нд цэвэр дүнгээр 157.6 сая ам.долларын Өмнөд Солонгос улсад бүртгэлтэй бондуудаас худалдан авсан бол 26-нд цэвэр дүнгээр 150.5 сая ам.долларын Индонез улсын бондуудын орох урсгал их байлаа.

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгө оруулагчид суларч буй хэрэглэгчийн итгэлийн индекс, сэтгэлд хүрэхгүй санхүүгийн үзүүлэлт болон коронавирусын тусламжийн төлөвлөгөөний талаарх АНУ-ын Конгресс доторх маргаан зэрэгт санаа зовниж Мягмар гарагт Уолл Стрийтийн арилжааг доогуур хаагдахад хүргэлээ. Dow Jones-ийг буурахад хүндээр нөлөөлсөн байгууллагууд нь II улиралд эрэлт нь эрс буурч хувьцаа нь 4.8% унасан аж үйлдвэрлэлийн конгломерат 3M Co болон дэлхий даярх салбаруудын өмнөх жилтэй харьцуулсан борлуулалт нь ихээр буурч хувьцаа нь 2.5% унасан McDonald’s корпораци байна. Dow Jones Industrail Average 205.49 нэгжээр доошилж 26,379.28, S&P500 0.65% буурч 3,218.44, Nasdaq Composite 134.18 нэгж буюу 1.27% алдаж 10,402.09 тус тус хүрээд байна.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мейлд хариу илгээнэ үү.